

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


2023.11.25

Сайншанд сум

Тус хэлтэс нь 2023 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, иргэнд төрийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх, зорилгоор “Цахим хүртээмжийг нэмэгдүүлж уламжлалт хандлагыг өөрчилнө” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.



Эзэн Чингис хааныхаа хөргийг хэлтсийн даргын өрөөний хойморт хүндэтгэлтэйгээр залав.



Дээрх зорилтын хүрээнд хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, бүртгэлийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Тоон гарын үсгийн програм, гадаад паспортын зургийн програм, иргэний улсын ахлах бүртгэгчийн засвар өөрчлөлт, нөхөн бүртгэлийн програм зэргийг шинээр нэвтрүүлж,

сүлжээний хэвийн ажиллагааг хангаснаар иргэдийн цаг зав, зардлыг хэмнэж, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх нөхцөл бүрдсэн.

2. 1990-2000 онд төрсөн нийт 1011 иргэний төрсний бүртгэл /ИУБ-11/-ийг мэдээллийн санд тулган шалгаж, 197 бүртгэлийн алдаа илрүүлэн Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан бичгийг нотлох баримтын хамт хүргүүлж, зөрчлийг арилгасан.

3. “Цаг хэмнэсэн - цахим үйлчилгээ булан”-ийн тоуч дэлгэцээр Э-Монголиа цэсээр нэвтэрч лавлагаа үйлчилгээг 1000 гаруй иргэн, киоск машинаар 300 гаруй иргэн цахимаар төлбөр төлсөн байна.



Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь нийт 3263 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Үүнд:

- Төрсний бүртгэл-1090
- Үрчилсний бүртгэл-18
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-59
- Эцэг тогтоосны бүртгэл-70
- Гэрлэлтийн бүртгэл -279
- Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл-75
- Нас баралтын бүртгэл-377
- Эх нотлох баримт, мэдээллийн сангийн мэдээллийн зөрчлийг арилгах засвар өөрчлөлтийн бүртгэл-67
- Нөхөн бичилтийн бүртгэл-131
- ИБЗ-1 бүртгэл-2
- Оршин суух хаяг тодорхойгүй төлөвт байгаа иргэнийг хаягийг суулгах-2

Иргэний бүртгэлийн нийт 6850 лавлагаа, үүнээс хууль хяналтын байгууллагад 432 лавлагаа, албан хэрэгцээнд 1175, иргэнд 5179 лавлагааг тус тус олгож, үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний шилжилт хөдөлгөөний чиглэлээр:

“Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу нийт 2630 иргэнд үйлчилгээ үзүүлсний дотор өөр аймаг, нийслэлээс шилжин ирсэн 788, сумаас шилжин ирсэн 848, баг хооронд шилжин ирсэн 1067 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулж баталгаажуулсан.

Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд үндэсний гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтыг 19960 Үндэсний энгийн гадаад паспорт 11507, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих олон удаагийн хавсралт 8310, нэг удаагийн хавсралт 143 бүртгэл хөтөлж, олгосон.

Иргэний үнэмлэх олгох ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд нийт олгосон иргэний үнэмлэх 2896, үүнээс шинээр олгосон иргэний үнэмлэх 1062, иргэний үнэмлэхээ гээгдүүлэн дахин олгосон иргэний үнэмлэх 251, иргэний үнэмлэхийн хугацаа дуусч 25, 45 насны сунгалт хийлгэсэн 1583 иргэнд иргэний үнэмлэх олгосон.

Иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдах 16 наснаас дээш насны иргэдийн судалгааг гарган, хурууны хээг авахаас өмнө мэдээллийн санд шалгаж, илэрсэн алдааг Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр албан бичгээр хүргүүлж, мэдээллийн санд тусгуулан ажилласан. 2023 оны 10 сараас иргэний улсын ахлах бүртгэгчид засвар өөрчлөлт, нөхөн бүртгэлийн программын эрхийг нээж өгсөн.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд болон багийн хүн ам, өрхийн мэдээллийн сан дахь хаягийн мэдээлэлтэй тулган шалгаж, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сайншанд сумын Багийн засаг дарга нарт албан бичиг хүргүүлэн хаягийн зөрчилтэй 757 иргэний хаягийн зөрчлийг арилгуулахаар хамтран ажилласан.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд:

Тоон гарын үсэг олгох батлагдсан хуваарийн дагуу төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын ажлын байранд хүрэлцэн очиж тоон гарыг үсгийг олгох ажлыг тогтмол явуулж байна. Одоогийн байдлаар Дорноговь аймгийн хэмжээнд нийт 3988 иргэнд тоон гарын үсгийг олгоод байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар Хаан банктай хамтран “ТООН ГАРЫН ҮСЭГ ОЛГОЛТЫГ ИДЭВХЖҮҮЛЭХ АЯН”-ы удирдамжийн дагуу Дорноговь аймгийн Хаан банктай хамтран

иргэд, харилцагч нарт тоон гарын үсэг олгох ажлыг 2023.03-06 сарын хугацаанд хамтран зохион байгуулсан .

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийг хууль тогтоомжийн дагуу бүртгэж баталгаажуулах, бүртгэлийн чанар, хяналтыг дээшлүүлэх зорилготой ажиллалаа.

Жилийн эцсийн байдлаар хэлтсийн хэмжээнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр иргэн, хуулийн этгээдээс 7359 мэдүүлгийг хүлээн авсан. Үүнээс:

- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 187
- Шинээр баригдсан орон сууц анх удаа бүртгүүлэх-160
- Төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрх баталгаажуулалт -14
- Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн анхны бүртгэл -577
- Худалдах, худалдан авах гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-1029
- Бэлэглэх гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл-393
- Арилжих гэрээ-1
- Барьцааны гэрээ-2299
- Барьцааны гэрээ дуусгавар болгох-2155
- Өв залгамжлах эрхийн бүртгэл-127
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх -12
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ -2
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 257
- Лавлагаа-235
- Бусад-146 тус тус бүртгэж үйлчилгээ үзүүлсэн.

Иргэн, хуулийн этгээдээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцуулахаар ирүүлсэн 54 хүсэлт нотлох баримтыг үндэслэн хяналтын байцаагчийн дүгнэлтийг гаргуулан гэрчилгээг дахин бичиж олгосон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хүсэлтээр иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн бүртгэлийн талаарх 235 лавлагааг хүргүүлсэн. Нийт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 7359 мэдүүлэг авч, бүртгэн, үйлчилгээний хураамжийн 154.373.245 төгрөгийг улсын төсөвт, 747.474.547 төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны татвар, тэмдэгтийн хураамж 4,895,491 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 7359 хувийн хэргийн эх нотлох баримтыг мэдээллийн санд цахимжуулсан баримттай тулган, нягтлан шалгаж илэрсэн зөрчлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 100 хувь арилгасан.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль”, холбогдох журам, бусад салбар хуулийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлсэн.

Тайлант хугацаанд дараах бүртгэлийг хийсэн. Үүнд:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээд нийт - 165
- Хуулийн этгээдийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан нийт 306 өргөдлийг хүлээн авч тус тус бүртгэсэн. / салбар-15, татан буусан-4 /.
- Хуулийн этгээдийн мэдээллийн сан, хувийн хэргээс нийт 44 лавлагаа, нийт 25 хуулбар олгосон.
- Тамга тэмдгийн хяналтын 223 дугаар олгож, 48 хуулийн этгээд тамга, тэмдгийг хураалгасан.
- Иргэний захиалсан 376 хуулийн этгээдийн нэрийг журмын дагуу баталгаажуулсан.

Нийт 1187 бүртгэл хөтөлж, үйлчилгээ үзүүлсэн.

Жилийн эцсийн байдлаар хураалгасан хуулийн этгээдийн тамга, тэмдгийг журамд заасан хугацаанд акт үйлдэн устгаж, холбогдох баримтаар хадгаламжийн нэгж бүрдүүлэн, эх нотлох баримтын архивт хүлээлгэн өгсөн.

Дорноговь аймгийн ИТХ-ын удирдамжийн дагуу Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын-үүд суманд үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллагуудад хяналт шалгалт хийх ажлын хэсэгт орон 2023 оны 10 сарын 30-с 11 сарын 2-ны өдрийг хүртэл ажилласан. 2023 оны 09 сарын 08-ны өдөр BEST хөтөлбөрийн сургалтын танхимд зохион байгуулагдсан Авилгатай тэмцэх газартай хамтран 12 аймагт зэрэг зохион байгуулсан “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж” сургалтанд хамрагдсан.

Сар бүрийн тоон мэдээ, холбогдох тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

Бүртгэлийн хяналтын чиглэлээр:

Бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх 18 заалт бүхий төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр боловсруулан, хэлтсийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Тайлант онд бүртгэлийн хяналтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хяналт, шалгалтын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 6/2626 тоот албан бичигт хавсаргаж ирүүлсэн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага болон шалгалтын дүнгийн талаарх илтгэх хуудаст дурдагдсан зөрчлийг арилгуулан тогтоосон хугацаанд нь хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар архивын эх нотлох баримт нь зөрүүгүй, зөвхөн цахим сангийн мэдээлэл зөрүүтэй ХААТР-11 маягт 34, ХААТР-12 маягт 1, ХААТР-13 маягт 3, ХААТР-14 маягт 3, ХААТР-15 маягт 26, эх нотлох баримт байгаа боловч цахим мэдээллийн санд тусгагдаагүй төрсний бүртгэл 91, гэрлэлтийн бүртгэл 40-ийг нөхөн бичиж тус тус тусгуулахаар Иргэний улсын бүртгэлийн газарт нотлох баримтыг хүргүүлж нийт 157 иргэний зөрчлийг арилгасныг хянасан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1 дэх заалт, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Улсын бүртгэгч нь иргэний улсын бүртгэлийг хүчингүй болгох бол шүүхийн шийдвэр, эсхүл хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн бүртгэнэ” гэж заасныг баримтлан 13 дүгнэлтийг үйлдэж хурууны хээ зөрсөн 4, бүртгэсэн төлөвтэй 13 зөрчил, овог нэрийн зөрүүтэй 1, цахим гадаад паспорт авах хүсэлтийг хүлээн авахдаа төрлийг буруу сонгож бүртгэж баталгаажуулсан 1, регистрийн дугаар буруу олгосон 1 зөрчлийг тус тус арилгасан.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д “Улсын бүртгэгч нь тухайн иргэний регистрийн дугаар, эсхүл нэг төрлийн иргэний улсын бүртгэл 2, эсхүл түүнээс олон удаа хөтлөгдсөн бол хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хүчингүй болгоно.” гэж заасныг баримтлан 1 зөрчлийг арилгасан.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Улсын бүртгэгч шүүхийн шийдвэр, эсхүл хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн дагуу иргэний улсын бүртгэлийн мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.” гэж заасныг баримтлан 3 дүгнэлт үйлдэж, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн төрлийг буруу сонгож бүртгэсэн 1 алдаа, мэдээллийн санд засвар өөрчлөлт хийхдээ гаргасан 2 алдаа, мэдээллийн санд үрчлэлтийн бүртгэлийн мэдээллийг буруу тусгасан 1 алдааг тус тус арилгасан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 10 удаагийн тайлангаар 94 эрхийн улсын бүртгэлд, Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1500 дугаар дүгнэлтийг үндэслэн засвар өөрчлөлт оруулсныг хянасан байна.

Хяналт шалгалтын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 6/5515 дугаар албан бичгийг хүлээн авч уг чиглэлийн дагуу нөхөн сонгууль болох Айраг, Эрдэнэ сумдын хэсгийн сонгогчдын жагсаалтад нийт 1608 сонгогч бүртгэгдэж, түр хасав нэмэлт тэмдэглэгээ тавигдсан 77 сонгогч, үндсэн сонгогч 1531 бүртгэгдсэнийг шалгахад зөрчил илрээгүй бөгөөд илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/829, А/984, А/600 тушаалуудын хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан. Сонгуулийн санал авах өдөр “Шуурхай баг”-ийн зүгээс итгэмжлэгдсэн ажилтнуудад сонгуулийн санал авах өдөр техник

тоног төхөөрөмжтэй хэрхэн ажиллах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гарсан аливаа асуудал, мэдээллийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж бэлтгэн хүргэсэн. Улсын бүртгэлийн байгууллагатай холбоотой санал, гомдол гараагүй. Аймгийн хэмжээнд 589 сонгогч буюу 38.45 хувь нь санал хураалтад хамрагдаж холбогдох хууль тогтоомжийн дагуу санал хураалтын ажиллагааг явуулж дуусган илтгэх хуудсыг хүргүүлсэн.


Иргэний улсын бүртгэлийн газраас 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр “Бүртгэсэн болон алдаатай төлөвтэй” бүртгэлийн зөрчлийг арилгуулахаар тус аймагт хамаарах 1 иргэний мэдээлэл ирүүлснийг цахим мэдээллийн санд холбогдох эх нотлох баримттай тулган шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулж, илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн газраас “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хоёроос дээш удаа бүртгэсэн, алдаатай бүртгэлүүдийн алдааг арилгах”-аар ирүүлсэн чиглэлийн дагуу 13 бүртгэлийг шалгаж, улсын бүртгэгчдэд заавар зөвлөмж өгч 5 бүртгэлийг баталгаажуулан, 6 дүгнэлтээр бусад зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж, “Илтгэх хуудас”-ыг 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 1/434 тоот албан бичгээр хүргүүлсэн.


Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/1614 дүгээр тушаал, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 5/7833 дугаар чиглэлийн дагуу эрхийн улсын бүртгэл хаасан 7 бүртгэлд заавар зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллав.

Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 3/10685 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд иргэдийн хаягийн зөрчлийг арилгах зорилгоор Аймгийн Засаг даргын 2023 оны А/718 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Уг захирамжаар баталсан удирдамжийн дагуу ажиллаж, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргад танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын саналыг боловсруулна.



Тус хэлтсийн 2023 оны хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Сайншанд сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Улсын бүртгэлийн хэлтсийн хамтран баталсан удирдамжийн дагуу Сайншанд сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй өмнө онуудад хийгдсэн шалгалтаар зөрчил илэрч байсан 1 хүн, 3 хуулийн этгээдэд 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд Сайншанд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн хүүхдийн эрхийн байцаагч Б.Энхтуяа, Цагдаагийн газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ч.Ганзориг, Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр нарын бүрэлдэхүүнтэй шалгалтыг зохион байгууллаа.



Өмнө хийгдсэн 2009 оны шалгалтаар 800 гаруй, 2017 оны шалгалтаар 540, 2020 оны шалгалтаар 291, 2021 оны шалгалтаар 75 зөрчил илэрч байсан бол 2022, 2023 онуудад иргэний бичиг баримт, улсын бүртгэлийн гэрчилгээ барьцаалсан зөрчил илрээгүй нь иргэд, хуулийн этгээдийн холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдлэг дээшилсэн, хэрэгжилт сайн байгааг харуулж байна.



Шалгалтын явцад иргэний бичиг баримт барьцаалахгүй байхыг анхааруулан холбогдох хууль эрх зүйн зөвлөгөө, санамжийг 18 хуулийн этгээд 1 иргэнд өгсөн.

Бүртгэлийн хяналтын чиглэлээр:

Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллав.

Энэ оны бүртгэлийн хяналтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт шалгалтыг 10 удаа хийсэн.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2471, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 1640, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 73, архивын чиглэлээр 394 бүртгэл шалгаж, нийт 449 зөрчил илрүүлэн арилгуулах арга хэмжээ авч ажиллав.

Бүртгэлийн зөрчлийг арилгахаар иргэд болон улсын бүртгэгчдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, тайлбарын дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 17, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 54 нийт 73 дүгнэлтийг боловсруулан зөрчлийг арилгасан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн.

**НИЙТ БОЛОВСРУУЛСАН 73 ДҮГНЭЛТЭЭС УЛСЫН БҮРТГЭГЧИЙН ГАРГАСАН
ЗӨРЧЛИЙГ ДҮГНЭЛТЭЭР АРИЛГАСАН МЭДЭЭ**
/2023.01.01-2023.11.25-ны өдрийн байдлаар/


№	Бүртгэлийн төрөл	Арилгасан зөрчлийн тоо	Хувь
1	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр	11	44%
2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр	14	56%
Нийт		25	100 %
73		25	35%

ДҮГНЭЛТИЙН БҮРТГЭЛИЙГ БҮРТГЭЛИЙН ТӨРЛӨӨР НЬ АНГИЛСАН СУДАЛГАА
/2023.01.01-2023.11.25-ны өдрийн байдлаар/

№	Бүртгэлийн төрөл	Гаргасан дүгнэлтийн тоо	Дүгнэлтэд эзлэх хувь
1	Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр	17	23.3%
2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр	54	73.9%
3	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр	2	2.8%
Нийт		73	100 %

Бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалт болон сар бүрийн мэдээ, судалгааг нэгтгэн гаргаж илэрч буй алдаа, зөрчилд дүгнэлт хийж, зөрчлийг давтан гаргуулахгүй байх үүднээс улсын бүртгэгчдэд дотоод албан бичгээр 7 удаа чиглэл, зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. Мөн дүгнэлтээр засагдаж буй улсын бүртгэгчдийн гаргасан зөрчлийн судалгааг бүртгэгч тус бүрээр гаргаж санамж анхааруулга өгч байна.

**БҮРТГЭЛ ХИЙХДЭЭ АЛДААТАЙ БҮРТГЭЖ, БАТАЛГААЖУУЛСНЫ УЛМААС ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТЭЭР ЗӨРЧЛИЙГ АРИЛГАСАН ТООН МЭДЭЭ**
/2023.01.01-2023.11.25-ны байдлаар/




Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 268 хүн, 3 хуулийн этгээдэд холбогдох 271 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 6915.0 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.



Аймгийн хэмжээнд шийдвэрлэгдэж буй зөрчлийг сумдаар нь болон төрлөөр нь ангилан сар, улирлаар судалгаа гаргаж ажилладаг. Тайлант онд хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн 271 зөрчлийн хэрэг материалыг аймгийн Прокурорын газарт хуулийн хугацаанд бүртгүүлж, хянуулсан.

Сайншанд сумын 8 баг, Замын-Үүд сумын 5 багийн ажлын алба, бусад 12 сумын багийн Засаг дарга нартай хамтран энэ онд 16 насанд хүрсэн 608 хүүхэд, 25 насанд хүрсэн 492 иргэн, 45 насанд хүрсэн 509 нийт 1609 иргэнд хуулиар тогтоосон хугацаандаа иргэний үнэмлэхийн бүртгэл хийлгэх талаар мэдээлэл хүргүүлэн ажилласан.



“Зөрчлөөс урьдчилан сэргийлье” нэртэй мэдээллийн самбарт иргэний, эд хөрөнгийн эрхийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр Зөрчлийн тухай хуульд тусгагдсан заалтуудын талаарх мэдээлэл болон тус аймагт 2010 оноос 2023 онуудад бүртгэлийн хяналтын чиглэлээр хийгдсэн ажлын үзүүлэлтээр тоон судалгаа гаргаж байршуулсан байна.





“Бүртгэлийн хяналт шалгалтын мэдээлэл” нэртэй самбарыг шинээр хийж хяналт, шалгалтын чиглэлээр холбогдох хууль, тогтоомж, статистик мэдээ, санамж анхааруулга, зөвлөмж зөвлөгөөг иргэдэд хүргэн ажилласан.

Мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна. Серверийн аюулгүй байдал, цоож, лац, дохиоллын системийг тогтмол шалгаж, серверийг асааж унтраах тохиолдолд ашиглалтын дэвтэр хөтлөлтийг байнгын хяналт тавьж байналга хэсэгт

Тайлант онд нийт 1628 ширхэг гарын авлага, санамж, боршуур хэвлэж иргэн хуулийн этгээдэд тараасан.



Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д тусгагдсан хуулиар тогтоосон хугацаатай бүртгэлүүдийг хуулийн хугацаанд бүртгүүлэхгүй байгаа зөрчлүүдийг бууруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж хамтран ажиллах саналыг Аймгийн Эрүүл мэндийн газарт 2023 оны 10 дугаар сарын 16-

ны өдрийн 1/608 тоот албан бичгээр, Сумын Засаг дарга нарт 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 1/609 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.


ДОРНОГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
Совьмбо цогцолбор, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Угас: 7052 2200, факс(976)7052 2200,
Цахим шуудан: Dornogovi@burtgel.gov.mn
Цахим хуудас: www.dornogovi.burtgel.gov.mn

2023.10.16 № 1/609
танай _____-ны № _____-т


Хамтран ажиллах тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр хуульчилсан.

Энэхүү хугацааг хэтрүүлж бүртгүүлсэн тохиолдолд Зөрчлийн хуулиар арга хэмжээ авдаг.

Манай байгууллагын зүгээс хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг хуулийн хугацаанд бүртгүүлэх, зөрчлийг бууруулах талаар төрөл бүрийн арга хэлбэрээр мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулж байгаа боловч уг зөрчлийн тоо буурахгүй байна.

Ялангуяа төрийн байгууллагуудын удирдлага өөрчлөгдсөн бүртгэл хуулийн хугацаанд хийгдэхгүй байгаад анхаарал хандуулж ажиллах шаардлагатай байна. Иймд танай суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд энэхүү хуулиар тогтоосон хугацааны талаарх мэдээллийг хүргүүлж, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллахыг хүсье.



СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ


ДОРНОГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
Совьмбо цогцолбор, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Угас: 7052 2200, факс(976)7052 2200,
Цахим шуудан: Dornogovi@burtgel.gov.mn
Цахим хуудас: www.dornogovi.burtgel.gov.mn

2023.10.16 № 1/608
танай _____-ны № _____-т


Хамтран ажиллах тухай

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д шинээр төрсөн хүүхдийг 30 хоногийн дотор, 13 дугаар зүйлийн 13.1-д нас барсан иргэнийг аймагт 3 хоногт, суманд 7 хоногт тус тус харьяалал харгалзахгүйгээр улсын бүртгэлийн байгууллагын өөрт ойр байрлах нэгжид хандаж бүртгүүлэхээр хуульчилсан.

Энэхүү хугацааг хэтрүүлж бүртгүүлсэн тохиолдолд Зөрчлийн хуулиар торгуулийн арга хэмжээ авдаг.

Манай байгууллагын зүгээс иргэдэд мэдээлэл хүргэх төрөл бүрийн ажил зохиож байгаа боловч уг зөрчлийн тоо буурахгүй байна.

Иймд иргэдэд СТ-4 маягт болон АМ-7 маягтыг олгож буй ажилтнууддаа энэхүү хуулиар тогтоосон хугацааны талаарх мэдээллийг хүргүүлж, иргэдийг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллахыг хүсье.



Архивын ажлын хүрээнд:

Иргэний гэр бүлийн бүртгэлийн мэдээний маягт болох ИУБ-11маягт 1090 ширхэг, ИУБ-12 маягт 82 ширхэг, ИУБ-13 маягт 59 ширхэг, ИУБ-14 маягт 70 ширхэг, ИУБ-15маягт 279 ширхэг, ИУБ-16 маягт 75 ширхэг, ИУБ-18 маягт 377ширхэг, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан болон 25, 45 насны сунгалт хийлгэсэн 2896 ширхэг ИУБ-31 маягт, нийт 4864 ИУБ маягтыг архивын санд байрлуулан, баяжилтыг тухай бүр хийсэн.

Тайлант хугацаанд өөр аймаг, хотоос шилжин ирсэн 921 иргэний хувийн хэргийг архивын санд байрлуулж, аймаг болон нийслэл рүү 1290 хувийн хэрэг явуулсан.

Тус архивт өнөөдрийн байдлаар насанд хүрсэн 46782 иргэний, насанд хүрээгүй хүүхдийн хувийн хэрэг 22948, нас барсан 10530 иргэний хувийн хэрэг, иргэний үнэмлэх аваагүй 115 иргэний, харьяатаас гарсан 95 иргэний хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн 2407 хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд тайлант хугацаанд хуулийн этгээдийн 169 бүртгэлийн баримтыг архив руу шилжүүлснийг ERS програмд архивлах төлөвт 100% шилжүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт үл хөдлөх эд хөрөнгийн 15134, газрын 9139 нийт 24375 хувийн хэрэг хадгалагдаж байгаа бөгөөд энэ онд үл хөдлөх эд хөрөнгийн 368, газар өмчлөх эрхийн 605 хувийн хэрэг шинээр үүссэнийг архивт хүлээн авсан.

Нийт эд хөрөнгийн 6910 бүртгэл архивт хүлээн авч байршуулсан.
Сар бүрийн архивын тоон мэдээг гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн.
Эд хөрөнгийн 24375 хувийн хэргийн хайрцагийг шинээр сольж хаягжуулсан.



Иргэний хувийг хэргийг тоолж, сүлжээнд тулгаж өөр аймаг болон нас барсан төлөвтэй хувийн хэргийг ялган авч өөр аймгийн харъяалалтайг харъяалалын дагуу жагсаалт үйлдэн явуулсан.



Нас барсан төлөвтэй хувийн хэргийг оны дараалал болон нэрийн үсгийн дарааллаар байршуулж нэг хайрцаганд 50 ширхэг хувийн хэргийг хайрцаглаж байршуулсан.



Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

Тайлант хугацаанд 668 албан бичиг явуулж, ирсэн 718 албан бичгийг хүлээн авч, заавар, стандартын дагуу бүртгэж, даргын цохолтоор холбогдох албан хаагчдад шилжүүлэн, хариутай 514 албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж, хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

УБЕГ-ын даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 15, хүний нөөцтэй холбоотой тушаал 34, бусад шийдвэрийн баримт бичгийг бүртгэн, танилцуулах хуудсаар нийт албан хаагчдад танилцуулж, биелэлтэд хяналт тавин, хэрэгжилтийг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлсэн.

Хэлтсийн даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 9, хүний нөөцтэй холбоотой 20 тушаалыг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж, даргаар батлуулан, холбогдох албан хаагчдад танилцуулсан

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чиглэлээр:

Тус хэлтэст тайлант хугацаанд Засгийн газрын 11-11 төвд-2 гомдол, бичгээр 18 өргөдөл гомдол ирсэн байна.

Нийт 20 өргөдөл гомдол ирүүлснээс

- Эд хөрөнгийн үйл ажиллагаатай холбоотой -1 гомдол,
- Албан хаагчийн зан харьцаатай холбоотой -2,
- Иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой-7,
- Гадаадад зорчих эрхийн бүртгэлтэй холбоотой-3,
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой-4,
- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой-3

Байгууллагын архивын чиглэлээр:

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021-2022 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг үйлдсэн.

Хэлтсийн 2022 онд хөтлөгдсөн баримтыг хяналтын байцаагч, нягтлан бодогч, холбогдох ажилтнаас хүлээн авч Байнга-13, Түр-73, 70 жил -10 хадгаламжийн нэгж бүрдүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсийн түүхчилсэн лавлахыг бичиж данс бүртгэл үйлдэн аймгийн БНШАЗК-ын 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар хурлаар батлуулж Хэлтсийн Байнга хадгалах 2009-2016 оны 81 хадгаламжийн нэгжийг аймгийн Төрийн архивт 247 дугаар хөмрөг үүсгэн Удирдлагын баримт хүлээн авсан акт, баримт шилжүүлсэн акт үйлдэн хүлээлгэн өгсөн.

Нягтлан шалгалтын явцад хадгалах хугацаа дууссан, түүх эрдэм шинжилгээний ач холбогдолгүй Иргэний бүртгэл мэдээллийн алба, Улсын бүртгэлийн хэлтсийн 2002-2019 оны 106 хадгаламжийн нэгжийн 17609 хуудас, ЭХЭУБА-ны 2001, 2006-2008 оны 18 хадгаламжийн нэгжийн 5421 хуудас хэргийг устгахаар ялгаж 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр УБТЗ-ын БОСАА-ийн уурын зууханд шатааж устгасан.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2009-2020 оны аймгийн БНШАЗК-ын хурлаар батлагдсан Байнга, Түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийг дугаарлаж, эмхлэн цэгцэлж, хаягжуулсан.

Хүний нөөцийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/424 тушаалаар тус хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг 29 баталсан.

Тайлант хугацаанд тус хэлтэс нь төрийн захиргааны 22, төрийн үйлчилгээний 4, гэрээт 2 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хэлтсийн даргын Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 20 тушаал гаргасан байна. Үүнд:

- Ажилд томилох, чөлөөлөхтэй холбоотой 4,
- Цалин хөлс, тэтгэмж, мөнгөн тусламж, урамшуулал, нэмэгдэл олгохтой холбоотой-16 тушаал гарсан байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 34 тушаал гарсан байна. Үүнд:
- Ажилд томилох, ажлаас чөлөөлөх, ажлаас чөлөөлж, албан тушаалд томилох, төрийн албанаас чөлөөлөх, -15,
- Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай-1
- Гэрээт албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоох тухай-2,
- Хоол унааны нөхөх төлбөрийг шинэчлэн тогтоох тухай-4,
- Сахилгын шийтгэл оногдуулах тухай-7,
- Аймгуудын Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг батлах тухай-1,
- Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг шинэчлэн тогтоох тухай-1,
- Мөнгөн урамшуулал олгох тухай-1

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар нийт 7 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан ба шийтгэлийн төрлөөр авч үзвэл:

- Сануулах арга хэмжээ авхуулсан-5,
- Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах 2 удаагийн арга хэмжээ авахуулсан 1 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.

Хуульд заасан бусад төрлөөр буюу Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт зөрчсөн, ёс зүйн зөвлөлийн шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй байна.

Тайлант хугацаанд 7 албан хаагчийг шагнаж урамшуулсан ба шагналын төрлөөр авч үзвэл:

- Байгууллагын шагнал : Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Хүндэт жуух бичиг” шагналаар -4 албан хаагч
- Засгийн газрын шагнал: Хуульзүй дотоод хэргийн яамны “Хүндэт Жуух бичиг” шагналаар -1, “Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан” шагналаар -1, Хуульзүй албаны тэргүүний ажилтан тэмдгээр -1 албан хаагч тус тус шагнаж урамшуулсан байна.

Төрийн захиргааны албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, төрийн албанд ажилласан болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газар дахь салбар зөвлөлөөс санал уламжилсны дагуу төрийн захиргааны 15 албан хаагчдад зэрэг дэв ахиулах болон шинээр зэрэг дэв олгосон. Үүнд:

- Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг – 5 албан хаагч,
- Дэс түшмэлийн гутгаар зэрэг- 4 албан хаагч

- Дэс түшмэлийн дэд зэрэг- 5 албан хаагч,
- Дэс түшмэлийн тэргүүн зэрэг-1 албан хаагчдад олгосон байна.

УБЕГ-аас 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 3/4644 тоот албан бичигт ажил үүргээ гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчиж бүртгэл хөтөлсний улмаас гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцлийг бүрдүүлж эрүүгийн хэрэгт холбогдох асуудал цөөнгүй гарч байгаа талаар сануулан Улсын бүртгэлийн багц хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг хууль холбогдох дүрэм журам, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ авилга ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, хуулийн хүрээнд ажиллахыг нийт албан хаагчдад сануулан, УБЕГ-ын даргын 2023 оны 11 сарын 13-ны өдрийн А/1716 тоот тушаалаар баталсан байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын үйлчилгээний стандарт, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн санамж эрхзүйн баримт бичигтэй танилцуулж Авилгаас ангид байх баталгааны хуудсанд гарын үсэг зуруулан албан хаагчдын хувийн хэрэгт хавсаргасан.

Шинээр томилогдсон Замын-үүд сумын улсын бүртгэгч Б.Сарантуяа, Хэнтий аймгийн улсын бүртгэлийн хэлтсээс Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн Замын-Үүд сумын улсын бүртгэгчээр шилжин томилогдсон Б.Сийлэгмаа нарт байгууллагын үйл ажиллагаа болон, үйлчилгээний стандарт, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёсзүйн дүрэм, УБЕГ-ын даргын баталсан Хөдөлмөрийн дотоод журам, иргэн, хуулийн этгээдийн хувийн мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн санд хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаандаа хэрэглэх, ашиглах, дамжуулах болон мэдээлэлтэй танилцуулж, өөрийн ажил үүрэгт хамааралгүй мэдээллийг дамжуулах болон мэдээлэлтэй танилцан, задруулбал ёсзүйн хариуцлага хүлээлгэх болон хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авах үндэслэл болохыг тасгийн дарга, Улсын ахлах бүртгэгч нар улсын бүртгэгчдэд анхааруулан тайлбарлаж өгсөн

Хүний нөөцийн программын бие даах хичээлийг судлан хэлтсийн бүх албан хаагчид шалгалтыг амжилттай өгөв.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧИД
БИЕ ДААХ ХИЧЭЭЛИЙГ СУДЛАСАН СУДАЛГАА

Д/д	Албан тушаал	Эцэг /эх/-ийн нэр, нэр	Ерөнхий мэдлэг	ИУБГ	ЭХЭУБ	ХЭУБ	УБНА
				ерөнхий	ерөнхий	ерөнхий	ерөнхий
1	2	3	4	5	9	13	17
Улсын Бүртгэлийн хэлтэс							
1	Хэлтсийн дарга	Цабишир Тэгшжаргал	95	88.3	88.3	87.5	95
2	Хяналтын улсын байцаагч	Өлзийчулуу Сонинбаяр	100	98.3	90	90	96.6
Иргэний улсын бүртгэлийн тасаг							
4	Улсын ахлах бүртгэгч, тасгийн дарга	Эрдэнэбаатар Уранбилэг	85	90	85	80	85
5	Улсын бүртгэгч	Жигжидсүрэн Болортуяа	85	88.3	86.6	97.5	95
6	Улсын бүртгэгч	Эрдэнэтөгтох Ариунтуяа	100	90	91	82.5	93.3
Нийт дүн:			5	5	5	5	5
Сумдын улсын бүртгэгч							
7	Айраг сумын улсын бүртгэгч	Лхаажавын Туул	97.5	95	50	82.5	96.67
8	Алтанширээ сумын улсын бүртгэгч	Сандагдорж Эрдэнэхишиг	100	96.67	81.67	80	90
9	Даланжаргалан сумын улсын бүртгэгч	Лимбэ Нямхүү	100	90	83.3		78.3
10	Дэлгэрэх сумын улсын бүртгэгч	Жанчив Өлзийжаргал	90	83.3	83.3		83.3
11	Иххэт сумын улсын бүртгэгч	Дүгэр Мөнхцэцэг	95	80	83.3	92.5	88.3
12	Замын-Үүд сумын улсын бүртгэгч	Содовжамц Шүрэндулам	97.5	91.67	83.3	90	96.67
13	Замын-Үүд сумын улсын бүртгэгч	Байдраг Сарантуяа	97.5	83.33	81.67	85	98.3
14	Өргөн сумын улсын бүртгэгч	Дамбачойдор Сарантуяа	100	86.67	86.67	92.5	93.3
15	Сайншанд сумын улсын бүртгэгч	Алтангарал Эрдэнэзаяа	97.5	80	88.3	82.5	85
16	Сайхандулаан сумын улсын бүртгэгч	Михлай Наранцацрал	97.5	85	78.33	87.5	91.67
17	Хатанбулаг сумын улсын бүртгэгч	Хурээт Хишигжаргал	95	90	85	80	93.3
18	Хөвсгөл сумын улсын бүртгэгч	Төмөртоого Энхтуяа	95	83.3	85	90	90
19	Эрдэнэ сумын улсын бүртгэгч	Чулуунбат Энхжаргал	100	90	85	92.5	81
Нийт дүн сумын бүртгэгч			13	13	11	10	13
Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг							
20	Улсын ахлах бүртгэгч, тасгийн дарга	Гунаасүрэн Батсайхан	100	90	90	87.5	90
21	Улсын бүртгэгч	Баттөмөр Баттуяа	97.5	80	83.3	80	90
22	Улсын бүртгэгч	Бибиш Сийлагмаа	95	96.67	88.33	82.5	88.3
Нийт:			3	3	3	3	3
Төрийн үйлчилгээний албан хаагчид							
23	Архивч	Цэрэндолгор Наранчимэг	95	83.3	83.3	95	83.3
24	Ахлах нягтлан бодогч	Ухнаа Буянбат	95	88.3	81.67	80	86.6
25	Мэдээлэл технологийн ажилтан	Пүрэв-Осор Азжаргал	100	91.67	85	95	90
26	Бичиг хэргийн ажилтан	Нэргүй Цэндмаа	100	8.3	88.3	95	90
Нийт:			4	4	4	4	4
Аймаг нийт			26	26	26	24	26

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг “Авилгатай тэмцэх жил” болгон зарласан билээ. Засгийн газраас хэрэгжүүлж буй “Авилгатай тэмцэх таван ажиллагаа”-ны нэг арга хэмжээ болох “шүгэл ажиллагаа”-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалан зохион байгуулж буй “Нэгдье” аянд тус хэлтэс нь нэгдлээ. Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй хэн бүхэнд “ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЭЭД ӨӨРЧИЛЬЕ” Авилгад үгүй гэж хэлье, Авилгын эсрэг НЭГДЬЕ гэсэн шторк хуудсыг Соёмбо цогцолборын үүдэнд болон үйлчилгээний заалны хаалганд байршуулсан.



Бид авилга авахгүй, та авилга өгөх хэрэггүй, бид танд үйлчлэх үүрэгтэй санамж хуудсыг үйлчилгээний заал болон мэдээллийн самбарт байршуулсан

Хяналтын улсын байцаагч, бичиг хэргийн ажилтны өрөөний үүдэнд болон архивын өрөөний гадна хаалганд “АВИЛГА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ХАМТ ОЛОН” гэсэн сурталчилгааны хуудсыг наан байршуулсан. Хэлтсийн албан хаагчдын авилга хээл хахууль, хүнд сурталын талаар мэдээлэл хүлээн авах 7052-2200 дугаарыг байршуулсан.



Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу хэлтсийн төрийн захиргааны нийт албан хаагчид ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргаж, хэлтсийн дарга баталгаажуулсан.

Тус газрын сургалтын хөтөлбөрт тусгагдсаны дагуу Дорноговь аймаг дахь Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Ч.Нандин-эрдэнэ 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр “Авлигын эсрэг хууль тогтоомжид тусгагдсан нийтийн албан тушаалтны анхаарах зүйл” сэдэвт сургалт, ярилцлагыг зохион явуулсан.

Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар иргэн, байгууллагаас санал, гомдол ирээгүй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Аймгийн Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан Цагдаагийн хошууч Ч.Ганзориг “Гэр бүлийн хүчирхийлэл түүний илрэл” “Архи, тамхины хор хөнөөл, “Хүчирхийллээс ангижрах 4 алхам” сэдэвт сургалтанд хэлстийн албан хаагчид хамруулсан. Тэс хэлтэс нь алба хаагчид болон иргэд, олон нийтийг аливаа хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, эрүүл, зөв хооллох, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийхийг уриалж, “ХОРТ ЗУРШЛААС ТАТГАЛЗАЖ- САЙНААР ҮЛГЭРЛЭЭ” нөлөөллийн аяныг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 21 хоногийн хугацаатай аяныг зохион байгууллаа. Архи, тамхины хор уршгийн талаарх богино хэмжээний видео шторкыг тус хэлтсийн үйлчилгээний танхимд дэлгэцээр тогтмол сурталчилан иргэн, олон нийтэд, архи, тамхинаас татгалзахыг уриаллаа.

Мэдээллийн технологи, програм хангамж, тоног төхөөрөмжийн ажлын хүрээнд:

Мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:

Хэлтсийн нийт 28 албан хаагчийн 37 компьютерийн үйлдлийн системийн нууц үг болон програмд нэвтрэх нууц үгийг сольж баталгаат гарын үсэг зуруулсан.

Замын-Үүд сум, Сайншанд суманд тоон гарын үсэг олгох зөөврийн компьютерийг үйлдлийн системийг шинэчилж Gsign програм суулгасан.

Хатанбулаг, Хөвсгөл сум, Замын-Үүд сумын видео конвертор шатсан байсныг шинээр сольж хэвийн үйл ажиллагааг хангасан.

Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн 2, иргэний бүртгэлийн 3, хяналтын улсын байцаагч, ахлах нягтлан бодогч, хэлтсийн даргын компьютерийг форматлаж шаардлагатай програмуудыг суулгаж бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд бэлэн болгож өгсөн. Иргэний бүртгэлийн тасгийн принтерийн алдааг тухай бүрд нь засаж таниулж ажилласан. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн принтерийн шинээр сольж хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Серверийн аюулгүй байдалд байнгын хяналт, цоож, лац, дохиоллын системийг тогтмол шалгаж, цэвэрлэгээ үйлчилгээг байнга хийж байсан. Мөн серверийг асааж унтраах тохиолдолд ашиглалтын дэвтэр хөтлөлтийг байнгын тэмдэглэл хөтөлсөн.

Хяналтын камерийн дэлгэц шатсан байсныг 2 удаа засварлуулсан. Мөн камерны бууруулагчийг сольж хяналтын камерын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах чиглэлээр дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд:

- Орон сууцны төсөлд хамрагдах хүсэлтэй албан хаагчдын судалгааг УБЕГ-т хүргүүлсэн.

- Албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан ажлаа үр дүнтэй сайн биелүүлж, санхүүгийн тайлангийн аудитын тайлангийн дүгнэлтээр 3 жил дараалан зөрчилгүй дүгнэгдсэн ахлах нягтлан бодогч У.Буянбатыг нэг сарын үндсэн цалингаар шагнаж урамшуулсан.
- Албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах хуваарийг
- аймгийн Нэгдсэн эмнэлэгт гарган хүргүүлж урьдчилсан үзлэгт 19 албан хаагч хамрагдсан.
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт ашиглагдаж буй принтер нь үйл ажиллагааны шаардлага хангахгүй элэгдэлд орж хуучирсан байсныг төсвийн хөрөнгөөр 1610000 төгрөгөөр 3 принтерийн асуудлыг шийдвэрлэсэн.

Санхүү, аж ахуй үйлчилгээний ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны 11 сарын байдлаар 292,656.2 мянган төгрөгийн үйлчилгээний орлогыг олж 292,656.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсөвт торгууль, шийтгэлийн орлогоор 6,915.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамжаар 15,663.4 мянган төгрөг, үл хөдлөх борлуулсны орлогоор 747.474.5 мянган төгрөг нийт 770.0 мянган төгрөгийн орлого оруулсан. Тус хэлтсийн зардлын төсөв 2023 онд 736,797.2 мянган төгрөгөөр батлагдсан. 11 сарын байдлаар 680,643.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, 657,589.7 мянган төгрөгийг зохих зардлуудад төсвийн хуваарийн дагуу зарцуулан ажилласан байна. Улсын бүртгэлийн хэлтсийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн программ ашиглаж олон улсын стандартад нийцүүлэн хөтөлж, байгууллагын мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хүрээнд байнгын хяналт тавьж, төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг 12 удаа хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж СТСХэлтэст болон УБЕГ-ын СААХ-т хүргүүлсэн. 2023 оны 1, 2, 3-р улирлын санхүүгийн тайланг гаргаж, УБЕГ-ын Санхүү аж ахуйн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн. 2022 оны санхүүгийн тайланд аудитын зөрчилгүй дүгнэлт авсан.

УБЕГ-аас болон бусад байгууллагаас 9662.6 мянган төгрөгийн үнэт цаас, маягт болон 9251.0 мянган төгрөгийн бусад бараа материалыг бэлтгэж хангалтыг тасалдуулалгүй, мөн бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан.

2023 оны 11 сарын байдлаар 129 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан.

Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь үндсэн хөрөнгө орлого авах, үнэт цаасны тооллого, хүчингүй болгосон үнэт цаас, үнэт цаасны зарцуулалт зэргээр 12 удаа хуралдаж шийдвэр гаргаж ажилласан.

УБЕГазрын 1/1008 албан бичгээр Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр УБЕГазарт “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд бий болсон хөрөнгө 12,036.5 мянган төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн 3 ширхэг болох тоног төхөөрөмжийг, мөн

Лүдээ-Очир ХХК-аас 19824.0 мянган төгрөгийн үнэ бүхий 16 ширхэг нягтруулсан шүүгээг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, ТӨБЗГазарт тогтоолын хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн.

УБЕГазрын А-1/1279 албан бичгээр УБЕГазраас балансаас балансад 13,600.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1 нэр төрлийн 20 ширхэг нягтруулсан шүүгээг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, 19824.0 мянган төгрөгийн үнэ бүхий 16 ширхэг нягтруулсан шүүгээг УБЕГазарт балансаас балансад шилжүүлэн хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлсэн.

Тус хэлтсийн төсвийн хөрөнгөөр Сервис зоне ХХК-аас 1610.0 мянган төгрөгийн 2 ширхэг хэвлэгч, 1 ширхэг 3 үйлдэлт хэвлэгч төхөөрөмжийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авсан.


УБХ-ийн 2023 оны 11 сарын 01-ний өдрийн 1/639 тоот албан бичгээр 25 нэр төрлийн 54 ширхэг 34764.4 мянган төгрөгийн хөрөнгийг актлах, ашиглалтын хугацаа дууссан боловч байгууллагын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах боломжтой 15 нэр төрлийн 28 ширхэг 11605.6 мянган төгрөгийн хөрөнгүүдийг дахин үнэлэх саналыг УБЕГазраар дамжуулан ТӨБЗГазарт хүргүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын дагуу гэрээний 2022 оны биелэлтийг дүгнэж тус хэлтэс нь 86 /В/ оноогоор дүгнэгдсэн.

Аймаг, нийслэл сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн хэлтсээс 2023 оны орон нутгийн нөхөн сонгуулийг амжилттай зохион байгуулж, Улсын бүртгэлийн байгууллагын хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн.


Аймгийн хэмжээнд нийт орон нутгийн нөхөн сонгуулийн 2 хэсгийн хорооны 2 итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, орон нутгийн нөхөн сонгуульд хуулиар хүлээсэн чиг үргийн дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, сонгуулийн 2 хэсгийн хороо тус бүрд хүргэх ажлыг зохион байгуулж, итгэмжлэгдсэн ажилтанд холбогдох цахим сургалтыг зохион байгуулсан. Сонгууль 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр амжилттай зохион байгуулагдсан.



**Бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд:
“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ” зохион байгуулсан байдал:**

Иргэдэд улсын бүртгэлийн хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, бүртгэлийн үйлчилгээ, мэдээллийг олон төрлийн байдлаар нийтэд шуурхай, чанартай хүргэхэд анхаарч, дараах ажлыг зохион байгууллаа.


Замын-Үүд суманд 2023 оны 03 сарын 16-17-ны өдөр, 04 сарын 07-08, 06 сарын 02-нд тус тус зохион байгуулж нийт 1504 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.



Алтанширээ суманд 02 сарын 09-нд “Нээлттэй хаалганы өдөрлөг, 2023 оны 05 дугаар сарын 16-наас 18-ны өдрүүдэд Тойг, Зараа, Хаяа багуудын төв дээр зохион байгуулж төрийн үйлчилгээг хүргэх нээлттэй хаалганы өдөрлөг 219 иргэнд мэдээлэл өгч, 57 иргэнд тоон гарын үсэг олгосон.



2023 оны 06 дугаар сарын 13-нд Айраг сумын 4 багийн 120 хүнд мэдээлэл өгч, тус өдөрлөгөөр 28 хүнд тоон гарын үсэг олгосон.



Даланжаргалан сумын 5 багийн 2023 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд 150 хүнд мэдээлэл өгч, тус өдөрлөгөөр 28 хүнд тоон гарын үсэг олгосон.





Улсын бүртгэгч С.Мөнхтуяа 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбадрах сумын 4 багийн 255 иргэдэд мэдээлэл хийсэн.



Улсын бүртгэгч Д.Мөнхцэцэг 2023 оны 06 дугаар сарын 04-ний өдөр Иххэт сумын 3 багийн малчны өдөрлөгт Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 180 гаруй иргэнд мэдээлэл хийсэн.



Аймгийн ИТХ-аас зохион байгуулсан нээлтэй хаалганы өдөрлөгт 14 сумын иргэдэд бүртгэлийн үйлчилгээ үзүүлэв.




БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАСАН БАЙДАЛ:

Хууль тогтоомж сурталчилах өдөрлөг -2023” Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилж, иргэдэд зөвлөгөө, тоон гарын үсэг олгож ажиллалаа.



2023 оын 03 дүгээр сарын 15-ны өдөр Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал DSB TV–д, DTV TV-д шинээр нэвтэрсэн цахим гадаад паспортын талаар болон “E-mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн порталаар үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээлэл өгч, цахим гадаад паспорт захиалсан иргэдийн гадаад паспортыг албан ёсоор гардуулан өглөө.



Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын дунд спортын цогцолборт тэмцээнд 13 байгууллагын 300 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж олс таталтын тэмцээний төрөлд хүрэл медаль авсан.



Монголын Хуульчдын холбооноос жил бүр уламжлан зохион байгуулдаг “Хуульчдын Про-бонo” болон “Нээлттэй Дорноговь” чуулган 2023 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус өдөр байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилж, иргэдэд зөвлөгөө, тоон гарын үсэг олгож ажиллалаа.



Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 139, 438 дугаар тогтоолуудаар “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтанд Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Г.Батсайхан нар хамрагдав.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд тус хэлтэс нь Сайншандаас сумаас зохион байгуулж буй бүх нийтээр мод тарих өдрийн нээлтэд нийт албан хаагчдыг хамруулж “Говийн парк” цэцэрлэгт хүрээлэнд 313 хайлаас модыг тарьж, услах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны ахлах референт Д.Пандиймаагаар ахлуулсан ажлын хэсэг 2023 оны 05 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Дорноговь аймагт ажилласан. Энэ үеэр аймгийн Засаг даргын ахалдаг “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүний үйл ажиллагааг шалган танилцаж тус байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон агентлагын дарга нарыг хамруулсан танхимын сургалтанд Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал, Хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг нар хамрагдав.



Аймгийн Улаан загалмайн хороо, Нэгдсэн эмнэлэгийн цусны төв хамтран 2005 оноос хойш жил бүр зохион байгуулагддаг Дэлхийн цусны донорын өдрийг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлсэн. Уг арга хэмжээнд Нигүүлслэл алтан медалиар улсын бүртгэгч Б.Сарантуяа, Нигүүлслэл мөнгөн медалиар ахлах нягтлан бодогч У.Буянбат, Хүмүүнлэг залуу алтан медиалаар бичиг хэргийн ажилтан Н.Цэндмаа нар шагнуулсан.



Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн нийгмийн тухай хичээлийг бататгах ажлын хүрээнд ахлах ангийн сурагч нар Улсын бүртгэлийн хэлтсийн ажлын байр болон үйл ажиллагаатай танилцав.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулж буй “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөдөлгөөн "ЦАГ ГАРГАЯ" аянд нэгдэв.



Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх “Стратегийн команд штаб”-ын сургууль, дадлагын хүрээнд хэлтсийн албан хаагчдын аранзны бүрдэл, хувцасны бэлэн байдлыг хангуулж, зарлан мэдээллийн дохиогоор ажиллах талаар мэдээлэл өгсөн.

Хэлтсийн даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг баталж, мөн хэлтсийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хянуулж батлуулсан.

2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 16.00 цагт Зарлан мэдээллийн дуут дохио 1 дуугарахад хэлтсийн албан хаагчид ширээн доогуур орж аюулгүй байдлаа хангаж, 2 удаа дуугарахад объектоос аюулгүйн гарцаар гарч аюулгүйн талбайд нүүн шилжиж ажилласан.



Эрээн хотын консулын газраас ивээн тэтгэсэн АЗДТГ, БШУГ хамтран зохион байгуулсан "Эрээн хотын 1өдрийн аялал"-д тус хэлтсийн албан хаагчийн 5 хүүхдийг хамруулсан. Аяллаар Эрээн хотын 3 дугаар сургууль, Үлэг гүрвэлийн музейгээр зочилж, байгаль орчин, танин мэдэхүйн мэдлэгээ хөгжүүлэн, 1 өдрийг сонирхолтой, дурсамжтай өнгөрүүлээ.



Нэгдсэн эмнэлэгийн ажилчдын мэдээллийн цаг дээр Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Э.Уранбилэг шинээр төрсөн хүүхдийн регистрийн дугаарыг буруу олгосноор иргэдийг чирэгдүүлж буй талаар мэдээлэл хийсэн. Нэгдсэн эмнэлэгийн ажилчдаас 57 иргэний тоон гарын үсэг авч хамтран ажиллав.

Төрийн цахим үйлчилгээг сурталчилах ажлын хүрээнд 03 сарын 10-нд Сайншанд сумын 3,8 дугаар багт, “Цахим Дорноговь” өдөрлөгийг 2023 оны 06 сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулж “Цаг хэмнэсэн цахим булан” үйлчилгээг иргэдэд сурталчилж тоуч дэлгэц болон киоск машинаар үйлчилгээ үзүүлсэн.

Мөн Сайншанд сумын Засаг даргын Тамгын газартай хамтран "Иргэдэд ээлтэй Эрүүл хот-2023" зорилтот жилийн хүрээнд иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийг сурталчлан таниулах, төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Иргэдэд ойр Төрийн үйлчилгээ" өдөрлөгийг 2023.06.13-16-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа.

**ИРГЭДЭД ОЙР
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

- Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар
- Захирагчийн ажлын алба
- Өрхийн эрүүд мэндийн тов
- Хурдан тов /E-Mongolia/
- Газрын харилцаа
- Улсын бүртгэлийн хэлтэс
- Хөдөлмөр халамж үйчилсээний газар
- Чандмань Илч ОНӨХХК
- Дорноговь аймгийн Цагдаагийн газар

1, 6-р баг 6 баатрын ард тоглоомын талбай 2023.06.13 15:00 Цагт	4, 7-р баг Төмөр замын клубын гална талбай 2023.06.14 11:00 Цагт
---	--



Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан уламжлал болгон зохион байгуулдаг “Албан хаагчдын гэр бүлийн өдөрлөг”-ийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр албан хаагчдын гэр бүл хүүхдүүдийн насны ангилалаар олон төрөлт хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулж, албан хаагчдын хүүхдүүдэд гарын бэлэг гардуулсан.



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хөдөлгөөнд оролцож байгаа жолооч, зорчигчдод зөв дадал, соёл, хандлагыг төлөвшүүлж, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Соёлтой жолооч” хэсэгчилсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулагдаж нийт жолооч нартаа хандан замын хөдөлгөөнд соёлтой, анхаарал болгоомжтой оролцохыг уриалсан уриалгад тус хэлтэс нь нэгдсэн.



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн төрийн захиргааны менежментийн ангийн 2 дугаар курсийн оюутнууд Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, зорилго, зорилт, ажлын байртай танилцах дадлага хийв.



2023 оны 3,6,9,11 зохион байгуулагдсан Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтад оролцогчдын хурууны хээ таниулах систем дээр иргэний улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг хариуцан ажилласан.



2023.11.26-ны анхдугаар үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан 16 насанд хүрсэн хүүхдийн Иргэний андгай өргөх ёслолыг зохион байгуулсан. Залуу үеийнхэнд эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, төр улсаа эрхэмлэн дээдлэх, эх орон ард түмнийхээ өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлан чин шударгаар амьдрах, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилготойгоор 16 нас хүрсэн сурагчид иргэний андгай өргөж, иргэний үнэмлэхээ гардан авлаа. Монгол улсын иргэний андгай өргөх ёслолыг Аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Замын-Үүд сумын ЗДТГ, Айраг сумын ЗДТГ -тай хамтран зохион байгуулж тус арга хэмжээнд 16 нас хүрч буй 336 хүүхэд хамрагдав.





Хэлтсийн дарга 2023 оны 10 сарын 01-нд тус байгууллагад ажиллаж байсан 4 ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлж, энэ онд хийсэн ажил болон, хууль эрхзүй, техник технологийн шинэчлэлээ тайлагнан цаашид хийгдэх ажлуудаа танилцууллаа. Ахмадууд ажиллаж байсан үеийнхээ дурсамж, дурьтадгалаас хуваалцан нэг өдрийг хамтдаа өнгөрүүлэн залуу үедээ хандан өөрсдийн ажил амьдралд тулгарч байсан хүндрэл бэрхшээл, сургамжит дурсамжаа хуваалцсан юм.



Дорноговь аймаг дахь Голомт банкны салбартай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Мөн тус банкнаас энэ онд шинээр мэндэлсэн 100 хүүхдэд хадгаламжийн дэвтэр нээж, гарын бэлгийг дамжуулан өгөв.




Тус хэлтсийн иргэний улсын ахлах бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар 2023 оны 11 сарын 02-нд Айраг сумын 81 иргэний гадаад паспортын захиалга авч, 9 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.



Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 83 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг угтаж "Намайг хамгаал" нөлөөллийн аяны хүрээнд Иххэт сумын сурагчдын дунд "УЛСЫН БҮРТГЭЛ МИНИЙ НҮДЭЭР" эссэ болон гар зургийн уралдааныг зохион байгуулав.





2023 оны 1 сарын 23-нд Иххэт сумын Улсын бүртгэгч Д.Мөнхцэцэг сум, багийн Засаг дарга, Газрын даамал, Татварын байцаагч, ЭМТ, “Ган тэгш” эм эргэлтийн сантай хамтран хөдөөгийн багт тойролт хийж мэдээ мэдээлийг 61 өрхийн 240 иргэнд хүргэж ажиллав.



Тус хэлтсийн албан хэрэгцээнд ашиглагдаж буй шилэн кабель нь Сайншанд сумын 3 дугаар баг 18 айлын дээврээс хэлтсийн байр буюу Соёмбо цогцолборын дээвэрт татагдсан байсан бөгөөд тус шугамын доор шинээр барилга баригдаж эхлэж байгаатай холбогдуулан дээрх шугамыг барилгын талбайгаас аюулгүй зайнд шилжүүлэх ажлын зардлыг Дорноговь аймгийн Засаг дарга орон нутгийн санхүүжилтээр 3126000 төгрөгийг шийдвэрлэн өгч шилэн кабелийг шилжүүлсэн.

Замын-Үүд сумын Засаг дарга хил зорчих олон удаагийн хавсралт бичдэг Olivetty принтр болох 1 900 000 төгрөгийг шийдвэрлэн авч өгсөн.

Замын-Үүд сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч, иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар 2 тусдаа ерөөнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлдэг байсныг тусад нь ерөө гарган нэгтгэж ажиллах нөхцөл байдлыг хангаж өгсөн.

Сургалтын чиглэлээр:

Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд тайлант хугацаанд алба хаагчид дараах сургалтуудад хамрагдсан.

УБЕГ-аас зохион байгуулсан дараах цахим сургалтад хамрагдсан. Үүнд:

1. 2023.01.19-нд “Хуурамч бичиг баримтыг таних, баримт бичгийн түгээмэл нууцлалууд” цахим сургалт /хэлтсийн албан хаагчид/
2. 2023.02.25-нд “Цахим гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан зохион байгуулах” цахим сургалт /хэлтсийн албан хаагчид/
3. 2023.03.28-нд “Амьдрах урлаг ба йога бясалгал” цахим сургалт /хэлтсийн албан хаагчид/
4. 2023.04.12-нд “Эд хөрөнгийн эрхийн улсын /ахлах/ бүртгэгч нарт” зориулсан цахим сургалт /Эд хөрөнгийн эрхийн /ахлах/ улсын бүртгэгч нар
5. 2023.06.02-нд “Ажлын байранд бэлдэх анхан шатны” цахим сургалт /хэлтсийн албан хаагчид/
6. 2023.06.12-нд “Хүний эрхийн үндсэн ойлголт” цахим сургалт /хэлтсийн албан хаагчид/
7. 2023.06.05-нд “Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, тус хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” цахим сургалт /хэлтсийн албан хаагчид/
8. 2022.06.02-нд шинээр томилогдсон бүртгэгч нарт анхаарах асуудал /Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Сарантуяа/
9. 2023.03.29-нд Иргэний улсын бүртгэлийн газраас өгөх чиглэл “ Нөхөн бүртгэлтэй холбоотой” Иргэний улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг
10. 2023.01.06-нд “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC программ”-ын цахим сургалт /Бичиг хэргийн ажилтан Н.Цэндмаа/
11. 2023.03.27-нд “Өгөгдлийн шинжилгээн”-ий цахим сургалт /хэлтсийн албан хаагчид/
12. 2023.01.24 “ 21 аймгийн УБХ-ийн дарга болон албан хаагч нарт зориулсан цахим сургалт /Хэлтсийн албан нийт албан хаагчид/
13. 2023.01.18 Авилгатай тэмцэх газрын төлөвлөгөөт сургалт/Хэлтсийн албан нийт албан хаагчид/
14. 2023.03.22 Төрийн албан хаагчдын эрх зүйн сургалт/Хэлтсийн албан нийт албан хаагчид/
15. 2023.11.23 Улсын бүртгэлийн онцлох ажлууд / Хэлтсийн албан нийт албан хаагчид/
16. 2023.10.28 Хүн худалдаалах гэмт хэрэг / Хэлтсийн албан нийт албан хаагчид/
17. 2023.11.22 Сумдын бүртгэгчдийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр мэргэшүүлэх, ажлын байранд бэлтгэх сургалт /Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар/
18. 2023.08.17 Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт / Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Ж.Болортуяа/
19. 2023.08.30 Хүн худалдаалах гэмт хэргийн өнөөгийн байдал, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчлан сэргийлэх / Хэлтсийн албан нийт албан хаагчид/
20. 2023.10.30 Хүний эрхийн ёс зүй / Хэлтсийн албан нийт албан хаагчид/

21. Стрессгүй ажлын байр даван туулах, сэтгэцийн эрүүл мэнд сургалт
22. 2023.10.25 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх тухай
23. 2023.10.31 Хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухаан чадварыг дээшлүүлэх сэдэвт сургалт / Хэлтсийн албан нийт албан хаагчид/
24. 2023.11.20 Улсын бүртгэлийн мэдээллийн санд ажиллах журам / Хэлтсийн албан нийт албан хаагчид/
25. 2023.11.22 Сумдын улсын бүртгэгчдийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр мэргэшүүлэх чиглэлээр мэргэшүүлэх байранд бэлтгэх сургалт /5 албан хаагч/
Нийт 24 арга хэмжээний хүрээнд 24 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 264 албан хаагчийг хамруулсан.

УБЕГ болон Хэлтэс, орон нутгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтад албан хаагчдыг хамруулсан. Үүнд:

1. 2023.01.02 Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан “ Авлигаас урьдчлан сэргийлэх” цахим сургалт / хэлтсийн нийт албан хаагчид/
2. Аймгийн Цагдаагийн газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан Цагдаагийн хошууч Ч.Ганзориг “Гэр бүлийн хүчирхийлэл түүний илрэл” “Архи, тамхины хор хөнөөл, “Хүчирхийллээс ангижрах 4 алхам” сэдэвт сургалтанд хэлстийн албан хаагчид хамрагдав.
3. 2023.05.07 Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан “”Чанарын форум” сэдэвт танхимын сургалт /Хэлтсийн 5 албан албан хаагчид/
4. 2023.05.26 Мэргэшсэн нягтлан бодогч нарын Дорноговь аймаг дахь салбараас зохион байгуулсан “Олон улсын стандартыг хэрэглээнд нэвтрүүлэх / нягтлан бодогч У.Буянбат/
5. 2023.04.20 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “Эрүүл мэндийн даатгал ашиглалтын тухай ойлголт “сэдэвт цахим сургалт/ Хэлтсийн нийт албан хаагчид /
6. 2023.04.26-28 “Нягтлан бодогч нарыг чадавхжуулах” сэдэвт танхимын сургалт / нягтлан бодогч У.Буянбат/
7. 2023.04.22 Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал авах хэлэлцүүлэг / 6 албан хаагч/
8. 2023.05.17-19 орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн иргэний улсын ахлах бүртгэгч нарыг ажлын байранд дадлагажуулах сургалт танхимаар / Иргэний улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг /
9. 2023.06.16 Үндэсний аюулгүй байдлын зөвлөл стратеги судалгааны хүрээлэн сургалт танхимаар /Хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал, Хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр, Иргэний улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг/
10. Архивын ерөнхий газраас “Архивын баримтыг үдэж хавтаслах аргачлал” цахим сургалтад /3 албан хаагч/
11. 2023.06.16 Мэргэшсэн нягтлан бодогч нарын институт “ Мэргэжлийн тасралтгүй хөгжил 2023” сэдэвт танхимын сургалт / нягтлан бодогч У.Буянбат/

12. 2023.05.12 Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал авах хэлэлцүүлэг / 5 албан хаагч/
13. 2023.10.19 Хурдан төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулах уулзалт сургалт / хэлтсийн 4 алан хаагч/
14. 2023.11.08-09 Сангийн яамнаас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан төсөвлөлт” сэдэвт сургалт / Нягтлан бодогч У.Буянбат/
15. 2023.08.30 Эрүүгийн цагдаагийн албанаас зохион байгуулсан “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай/ Хэлтсийн албан нийт албан хаагчид/
16. Аймгийн Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний албанаас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан удирдлага, бодлогын уялдаа / Иргэний улсын ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч/
17. 2023.11.27 Сангийн яамнаас зохион байгуулсан ТСУЦС-ийн хөгжүүлэгдсэн хялбаршуулсан гүйлгээ болон хяналт, үүрэг модуль / Нягтлан бодогч У.Буянбат/
Нийт 17 арга хэмжээний хүрээнд 17 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 120 албан хаагчийг хамруулсан.

ТАЙЛАН БИЧСЭН:

Э.УРАНБИЛЭГ

ТАЙЛАН ХЯНАСАН:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТЭГШЖАРГАЛ